



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 10 сарын 13 өдөр

Дугаар 378

Улаанбаатар хот

Г “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д Г  
үүрэг, даалгавар өгөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4.2 Хорооноос “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн үйл ажиллагаанд 2015 оны 9 дүгээр сард хийсэн газар дээрх хяналт, шалгалтын дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

НЭГ. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл /Б.Нямаа/, гүйцэтгэх захирал /М.Болор/-д дараах дараах үүрэг даалгаврыг өгсүгэй. Үүнд:

1. Компанийн тухай хуулийн 59.4-т зааснаар 2014 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулж, хуульд заасан холбогдох баримт материалыг хувьцаа эзэмшигчид танилцуулж, Хороонд ирүүлэх;

2. Компанийн тухай хуулийн 94.2, 94.3-т заасны дагуу компанийн дүрэмд өөрчлөлт оруулан аудиторыг томилон ажиллуулж, аудиторын шалгалтыг тогтмол хийлгэдэг болох;

3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 35.1-д заасны дагуу “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д мэргэжлийн ажил, үйлчилгээ эрхэлж буй ажилтан, мэргэжилтнүүдийг холбогдох сургалтад хамруулж, тогтвор суурьшилтай ажиллуулах, үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтний эрх авсан байх шаардлагыг хангах;

4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.1.3-т заасан “Үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх, хасах болон арилжаанд оруулах журам”-ыг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 54.1-т “Зохицуулалттай этгээд нь тухайн санхүүгийн тайлангийн жил дуусах тухай бүр нягтлан бодох болон бусад бүртгэлдээ аудитын шалгалт хийлгэж, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан хувийг аудитын дүгнэлтийн хамт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлнэ” гэсэн үүргийг хэрэгжүүлж ажиллах;

6. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн Хөрөнгийн биржийн үйл ажиллагааны тайланг хагас жил болон жилийн эцсийн байдлаар цахим хуудсаар нийтэд мэдээлэх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нийтэд хүргэх;

7. Хөрөнгийн биржийн бизнес төлөвлөгөөг шинэчлэн батлах;

001025

8. Хөрөнгийн биржийн “Бүртгэлийн журам”-д заасан шалгуур, шаардлагыг хангахгүй байгаа хувьцаат компанийн үнэт цаасыг Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасах, хөрөнгийн биржийн бүртгэлийг цэгцлэх ажлыг зохион байгуулах;

9. Хөрөнгийн биржийн баталсан “Арилжааны журам”, “Гишүүнчлэлийн журам”, “Мэдээллийн журам” зэргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон шалгалтын дүгнэлтэд заасантай нийцүүлж, өөрчлөлт оруулах;

10. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.1.4-т заасны дагуу Хөрөнгийн биржийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 2015/06 дугаар тогтоолоор батлагдсан “Арилжааны журам”-ыг Хороогоор батламжуулах;

11. Хөрөнгийн биржийн үнэт цаасны зах зээлд арилжаа эрхлэх үйл ажиллагааны зохицуулалтыг нэг мөр ойлгомжтой, тодорхой болгох үүднээс Хөрөнгийн биржийн зохицуулалтын журам, зааварт гишүүн үнэт цаасны компани, бүртгэлтэй хувьцаат компани болон мэргэжлийн холбоодын саналыг тусгаж, Хороогоор хуульд заасан журмын дагуу тухай бүр батламжуулж ажиллах;

12. Хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниудын үйлчилгээний шимтгэл, хураамжийн хэмжээг тогтмол байдлаар бус, үнэт цаасны компанийн арилжаанд оролцсоноор нь ялгавартай тогтоож, бууруулах;

13. Хорооны шийдвэрээр үнэт цаасны бүртгэлээс хасагдаж буй хувьцаат компанийг Хөрөнгийн биржийн бүртгэлээс нэн даруй хасч, Хорооны тогтоолыг үндэслэн Хөрөнгийн биржийн бүртгэлээс хассан хувьцаат компанийн мэдээллийг тухай бүр Хороонд мэдэгдэж, бүртгэлийг цэгцлэх ажлыг зохион байгуулж, энэ чиглэлээр гарсан Хорооны шийдвэрийг тухай бүр биелүүлэх;

14. Хорооноос үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын чиглэлээр гаргасан тогтоолын хэрэгжилтийг улирал бүрийн дараа сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлж тайлагнаж байх;

15. Хорооноос батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, улирал бүр тайлагнаж ажиллах;

16. “Хөрөнгийн биржийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэх, үүсгэсэн авлагын насжилтын талаар тодорхой тусгах;

17. Санхүүгийн тайланд тусгагдсан хуримтлагдсан авлагын асуудлын талаар төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороогоор дүгнэлт гаргуулах, хуримтлагдсан авлагыг санхүүгийн тайлан тэнцлээс цэвэрлэх ажлыг зохион байгуулах;

18. Эрсдэлийн удирдлагатай холбоотой тухайлсан бодлогын баримт бичиг, журмыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах;

19. Үнэт цаас гаргах үйл ажиллагааг дэмжих, компаниудыг идэвхжүүлэх, энэ талын мэдлэг, мэдээлэл хүргэх чиглэлээр үе шаттай ажлыг тодорхой хөтөлбөрийн дагуу гишүүн үнэт цаасны компани болон бусад холбогдох байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулах;

20. Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компаниудын мэдээллийн ил тод нээлттэй байдал, түүний чанар болон компанийн засаглалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

ХОЁР. Энэхүү тогтоолоор өгөгдсөн үүргийн биелэлтийг 2015 оны дөрөвдүгээр улиралд багтаан ирүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл /Б.Нямаа/, гүйцэтгэх захирал /М.Болор/ нарт үүрэг болгосугай.

ГУРАВ. Энэхүү тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА